

АШУҮИС-ийн элсэлттэй холбоотой FAQ

| АСУУЛТ | ХАРИУЛТ |
|---|---|
| Улаанбаатар хотоос элсэгч хэрхэн бүртгэлийн сайтад нэвтрэх вэ? | http://burtgel.mnums.edu.mn хаягаар Боловсролын үнэлгээний Төв /БҮТ/-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үг ашиглан нэвтрэнэ. |
| Бүрэн дунд боловсролын дундаж оноог яаж бодох вэ? | <p>Бүрэн дунд боловсролын дундаж бодохдоо нийт судалсан хичээлүүдийн дунджийг бодно.</p> <p>/Үүнд: сонгон суралцсан хичээлийг тооцож бодно. Улсын шалгалтын дүнг ТООЦОХГҮЙ!</p> <p>Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Үндсэн хичээл -15 • Сонгон хичээл – 3 байна гэвэл <p>Нийт 18 хичээл дүнгийн нийлбэрийг 18-д хуваана. Суралцагчийн дүн 92.632584 гэх мэтчилэн гарсан бол 92.63 гэж бичнэ.</p> |
| Дунджаа буруу оруулсан бол яах вэ? | Бүртгэлийн системийн ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ хэсэгт дундаж оноогоо дахин засварлан ХАДГАЛАХ товчийг дарснаар засагдах болно. |
| Е-Пин код яаж авах вэ? | <p>Е-PIN код нь зөвхөн ХААН Банкны карт эзэмшигч ХААН Банкны интернет худалдаа, үйлчилгээ эрхэлдэг байгууллагаар төлбөр тооцоо хийхэд зориулагдана. Төлбөрийн карт тус бүр дээр Е-PIN код авна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төлбөрийн картаа АТМ-нд хийн хэлээ сонгоод, Пин кодоо хийнэ. 2. Дэлгэцийн баруун доод хэсэгт байрлах “Пин код” гэсэн цэсийг сонгоно. 3. Дараа нь “Е-Пин код авах” цэсийг сонгоно. 4. Мартахааргүй 4 орон бүхий кодыг оруулна. /Харилцагч өөрөө зохионо/ 5. Кодыг дахин давтан оруулж баталгаажуулна. Энэхүү 4 оронтой код нь таны интернет худалдаа үйлчилгээнд хэрэглэгдэх код юм. Та Е-Пин кодоо мартсан тохиолдолд дээрх үе шатыг дахин давтана. |
| Төлбөр төлөх оролдлого хийсэн боловч амжилтгүй гээд байна яах вэ? | <p>Картны доорх мэдээллийг зөв оруулна уу!</p> <ul style="list-style-type: none"> - Карт эзэмшигчийн мэдээлэл - Картны ард байрлах CVV код буюу 3 оронтой тоо - КАРТНЫ ДУУСАХ ОГНООГ |
| Хэрхэн бүртгэл амжилттай болсныг шалгах вэ? | <ol style="list-style-type: none"> 1. Сонгосон мэргэжлүүдийн жагсаалтын дээр ногооноор "Бүртгэл баталгаажсан тул хэвлэх товчоор бүртгэлийн хуудсаа хэвлэж авна уу." 2. Төлбөр хэсэгт "Төлбөр төлөгдсөн" гэж гарч ирж байгаа бол таны бүртгэл АМЖИЛТТАЙ болсон гэсэн үг юм. |

| | |
|--|---|
| <p>Миний бүртгэл амжилттай болжээ. Би юу хийх ёстой вэ?</p> | <p>Улаанбаатар хотоос элсэгчдийн жагсаалт 2019.06.25-ны өдрийн 13:00 цагт гарна.</p> <ul style="list-style-type: none"> - http://burtgel.mnums.edu.mn хаягаар - https://www.facebook.com/burtgel.mnums.edu.mn/ - АШУҮИС-ийн Хичээлийн төв байрны зарлалын самбар |
| <p>Би Улаанбаатар хотоос тэнцсэн тохиолдолд яах вэ?</p> | <p>Жагсаалтын дагуу сонгосон мэргэжил, хөтөлбөрт тэнцсэн элсэгчдийг</p> <p>2019.06.25-нд 14:00-18:00 2019.06.26-нд 09:00-17:00 2019.06.27-нд 09:00-17:00 2019.06.28-нд 09:00-17:00 2019.06.29-нд 09:00-17:00 цагуудад АШУҮИС-ийн төв байрны 139, 140 тоот өрөөнд бүртгэнэ.</p> <p>Элсэгчид нь суралцах эрхийн бичиг авахаар ирэхдээ дараах материалыг бүрдүүлсэн байна Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүрэн дунд боловсролын үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримт (эх хувилбар) 2. Ерөнхий шалгалтын батламж (эх хувилбар) 3. Хувийн хэрэг 4. Иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах бичиг баримт (эх хувилбар) 5. Сүүлийн нэг жилд авхуулсан цээж зураг 4 хувь 6. Сургалтын төлбөрийг төлсөн баримт 7. Мультифор буюу нүхтэй хавтас 8. Анкет /сургуулийн үүднээс авах/ 9. Сургалтын төлбөрийн данс: Хаан банк дахь АШУҮИС-ийн 5107018784, код 101 <p>АШУҮИС-ийн элсэлтийн журмын 2.4.8 (Хяналтын тоонд багтсан боловч заасан хугацаанд шаардагдах материалыг бүрдүүлж ирж бүртгүүлээгүй элсэгчийн суралцах эрхийг цуцалж жагсаалтад буй дараагийн элсэгчийг нөхөн бүртгэнэ.) –д заасны дагуу 2019.06.29-ны өдрийн 09:00 цагаас 12:00 цагийн хооронд дараагийн шаардлага хангасан нэмэлт элсэгчдийг хүлээж авна. Эдгээр элсэгчдийн нэрсийг жагсаалтад СААРАЛ өөр өнгөөр тэмдэглэсэн байна.</p> |

АШУҮИС-ийн Элсэлтийн комисс

11-326894, 11-328894